




ХИШИГ-ӨНДӨР СУМЫН ХОГ ХАЯГДАЛ ЗОХИЦУУЛАХ СХЕМИЙН ЗӨВЛӨМЖ



Бэлтгэсэн: Экосум ТББ-ын Гүйцэтгэх захирал **Гэрбэр овогтой Пиэр**
Батласан: Экосум ТББ-ын Тэргүүн **Гүрсэд овогтой Нарантуяа**

ДЭД ХУВИЛБАР 2021 оны 6 дугаар сар
(2021 ОНЫ 4 САРД ХЭВЛЭГДСЭН АНХНЫ ХУВИЛБАРААС ШИНЭЧЛЭГДЭВ)

Энэхүү зөвлөмжийг Европын Холбооны санхүүжилттэй хэрэгжиж буй "Монгол улс дахь хуванцар хог хаягдлын дахин боловсруулалтын тогтвортой байдлыг хангах" төслийн хүрээнд боловсруулсан хэдий ч энд илэрхийлсэн үзэл бодол нь Европын Холбооны байр суурийг илэрхийлэхгүй болно.

ГАРЧИГ

ТАНИЛЦУУЛГА.....	4
1. ХОГ ХАЯГДЛЫГ ЭХ ҮҮСВЭР ДЭЭР НЬ АНГИЛАХ	4
ХОГОО АНГИЛАХ ҮНДСЭН АНГИЛАЛУУД, АНХААРАХ ГОЛ ДҮРМҮҮД	4
ХОГ ҮҮСГЭГЧИЙН ТӨРЛӨӨС ХАМААРАХ АНГИЛАЛТ, АШИГЛАХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	5
2. ХОГ ХАЯГДАЛ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ	5
ХОГ ҮҮСГЭГЧИЙН ХАРИУЦЛАГА	5
ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨВ ДЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АЧ ХОЛБОГДОЛ	5
3. ХОГ ХАЯГДАЛ ЗОХИЦУУЛАХ ТӨВ	6
ХОГ ХАЯГДАЛ ЗОХИЦУУЛАХ ТӨВИЙН БАЙРШИЛ	6
ХХЗТ-ИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ, ДЭД БҮТЭЦ.....	6
ХОГ ХАЯГДАЛ ЗОХИЦУУЛАХ ҮНДСЭН БОЛОН АГУУЛАХЫН БАРИЛГА.....	7
ЭЦСИЙН ХОГ ХҮЛЭЭН АВАХ ЦЭГ	9
ХОГ ҮҮСГЭГЧИЙН МАРШРУТ.....	9
ХОГ ХАЯГДЛЫН АЖИЛТНЫ ЗОХИЦУУЛАХ ДАХИВАР ХОГ ХАЯГДЛУУД	9
ХОГ ХАЯГДЛЫН АЖИЛТНЫ ЗОХИЦУУЛАХ ЭЦСИЙН ХОГ	11
4. ТӨВЛӨРСӨН ХОГИЙН ЦЭГ	11
ХУУЧИН ТӨВЛӨРСӨН ХОГИЙН ЦЭГИЙН ТАЛБАЙГ ХУМИХ, ХАМГААЛАХ	11
ХАШИЖ ХАМГААЛСАН ЛАНДФИЛЛИЙН АШИГЛАЛТ	12
5. БУСАД ОНЦГОЙ ХОГ ХАЯГДАЛД ЗОРИУЛСАН ЦЭГҮҮД	12
АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ.....	12
АМЬТНЫ СЭГ ЗЭМ.....	13
БОХИРЫН ХАЯГДАЛ.....	13
6. САНХҮҮГИЙН ЭХ ҮҮСВЭР БОЛОН ХАРИУЦАГЧ ТАЛУУД	13
САНХҮҮГИЙН ЭХ ҮҮСВЭР	13
ХАРИУЦАГЧ ТАЛУУД.....	13

ТАНИЛЦУУЛГА

Европын Холбооны SWITCH-Asia-II хөтөлбөрийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Монгол улс дахь хуванцар хог хаягдлын дахин боловсруулалтын тогтвортой байдлыг хангах” төслийн хүрээнд Экосум ТББ-аас Хишиг-Өндөр сумын хог хаягдлыг зохистой зохицуулах схемийг бий болгох зөвлөмжийг бэлтгэн гаргалаа. Энэхүү зөвлөмж нь 2021 оны 1 дүгээр сард гаргасан суурь судалгааны үр дүнд тулгуурласан болно. Тус тайланг Экосум-ын вэб хуудаснаас үзнэ үү:

www.ecosoum.org/mn-resources-and-reports

Хишиг-Өндөр сумын хог хаягдлын схемийн үндсэн бүрдэл хэсгүүдийн талаарх зөвлөмжүүдийг хог үүсэхээс эхлээд устгах хүртэлх явцын дарааллын дагуу бэлтгэснийг доороос үзнэ үү.

1. ХОГ ХАЯГДЛЫГ ЭХ ҮҮСВЭР ДЭЭР НЬ АНГИЛАХ

ХОГОО АНГИЛАХ ҮНДСЭН АНГИЛАЛУУД, АНХААРАХ ГОЛ ДҮРМҮҮД

Бүх хог үүсгэгчид – өрх (сумын төвийн болон малчин), төсвийн байгууллагууд болон хувийн бизнес – Экосум ТББ-аас зөвлөж, сумын ЗДТГ-аас батласан ангиллуудын дагуу хог хаягдлаа эх үүсвэр дээр нь ангилна.

Бүх хог үүсгэгчид хог хаягдлаа ангилах **үндсэн ангилалууд** нь (өнгөний код нь бидний тарааж өгсөн гарын авлагад ашигласан өнгө болно):

- **Дахивар хаягдал;**
- **Хоол хүнсний хаягдал болон органик хаягдал;**
- **Үнс;**
- **Аюултай хог хаягдал;**
- **Эцсийн хог хаягдал.**

Эх үүсвэр дээр нь ангилах дэд ангилалууд нь:

- **Хатуу хуванцар** (ус ундааны сав болон бусад хатуу хуванцар савнууд);
- **Зөөлөн хуванцар** (хуванцар уут болон хүнсний баглаа боодол);
- **Шил** (бүтэн болон хагарсан лонх, шилэн савнууд);
- **Цаас, картон, Тетрапак болон бөс даавуу** (гарах хэмжээнээс хамаараад нэг шүүдайд эсвэл тус тусад нь);
- **Метал** (төмөр, хөнгөн цагаан лаазнууд болон бусад төмрийн хаягдал);
- **Электрон барааны хаягдал болон зай хураагуур;**
- **Ногоо, жимсний хальс** (ногооны хальс, бусад ногоон хаягдал);
- **Амьтны гаралтай хаягдал** (мах, яс, өөх, хоолны үлдэгдэл гм.);
- **Модны үнс** (аргалын үнс бага зэрэг холилдсон байж болно);
- **Нүүрсний үнс** (модны үнстэй холилдоогүй цэвэр байх);
- **Аюултай хог хаягдал** (машины тос, будаг гэх мэт төрөл төрлөөр нь салгаж хадгалах);
- **Эцсийн хог хаягдал** (эргэлтэнд оруулах боломжгүй бусад хог хаягдал).

Хог үүсгэгчид өөрсдийн хог хаягдлаа эх үүсвэр дээр нь өөрт зохистойгоор хэрхэн ангилахаа (үндсэн болон дэд ангилалуудаар) өөрөө шийдэх боломжтой бөгөөд хамгийн чухал нь дараа нь хог хаягдал зохицуулах төвд өөрөө аваачихдаа (эсвэл ачих үйлчилгээнд өгөхдөө) дэд ангилалуудад салгахад хялбар байх нь чухал юм.

ХОГ ҮҮСГЭГЧИЙН ТӨРЛӨӨС ХАМААРАХ АНГИЛАЛТ, АШИГЛАХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

Сумын төвийн өрхүүдэд сумын ЗДТГ-ын захиалгаар Экосум ТББ-ын үйлдвэрлэсэн дахивар ангилах сав тараагдах бөгөөд тусгайлан бэлтгэсэн гарын авлагын дагуу (Экосум-ын вэб хуудсанд нээлттэй байршуулсан) өрхүүд өөрсдийн нэмэлт нөөц бололцоог ашиглан дээрх ангиллуудаар ангилна.

Малчин өрхүүдэд (сумын төвийн өрхүүдийнх шиг сав тараагдахгүй) эдэлгээ сайтай, чанартай шуудайнуудад хог хаягдлаа ангилахыг зөвлөж байна. Малчин өрхүүдийн хувьд хогоо зөвхөн үндсэн ангиллуудын дагуу ангилах нь хотондоо хэтэрхий олон шуудай сав хадгалах бэрхшээл тулгарахаас сэргийлнэ. ХХМТ-д дахиваруудаа авч ирэхдээ дэд ангиллуудын дагуу шууд ангилж хийх боломжтой юм.

Төсвийн байгууллагуудын хувьд Булган аймгаас тарааж өгсөн том төмөр хогийн савыг сайжруулан дахивар хадгалах түр сав болгон ашиглаж болох юм. Ажлын байрандаа хялбараар үр дүнтэй (дээр дурдсан шаардлагуудын дагуу) ангилах аргыг байгууллага бүр дотооддоо хэлэлцэж олох нь зүйтэй.

Хувийн бизнес эрхлэгчид эх үүсвэр дээр нь хог хаягдлаа ангилах, дахивараа хэрхэн түр хадгалах гэх мэтийг өөрсдийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, хамтдаа шийдвэрлэх нь зүйтэй.

2. ХОГ ХАЯГДАЛ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ

ХОГ ҮҮСГЭГЧИЙН ХАРИУЦЛАГА

Сумын ЗДТГ эсвэл Экосум ТББ-аас албан ёсоор хог хаягдал цуглуулан тээвэрлэх үйлчилгээг албан ёсоор эхлүүлэх хүртэл сумын төвийн болон хөдөөгийн өрхүүд, аж ахуй нэгж, албан газрууд хог хаягдлаа (эх үүсвэр дээр нь ангилсан) өөрсдийн нөөц бололцоогоор ХХЗТ-д хүргэж өгөх үүрэгтэй.

ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨВ ДЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АЧ ХОЛБОГДОЛ

Бүх төрлийн хог хаягдлыг – үнс болон эцсийн хогийг оруулаад – хог хаягдлын менежментийн төвд хүргэж өгөх бөгөөд үйлдвэрийн хашаа, барилгад хог хаягдал тус бүрийг тодорхой аргаар зохицуулах болно (үүнд хог үүсгэгчдийн идэвхтэй оролцоо маш чухал болохыг дор тайлбарлана). Ямар ч хог хаягдлыг (эцсийн хог хаягдал байсан ч) төвлөрсөн хогийн цэгт зөвхөн эрх бүхий хүн л тусгайлан заасан газарт хүргэж хаяна.


Хэрэв хог хаягдал цуглуулах, ачих үйлчилгээг албан газар, бизнес эрхлэгчдэд эсвэл зөвхөн өрхүүдэд гэх мэтээр хэсэгчилэн хүргэх, эсвэл бүх төрлийг хог үүсгэгчдэд зориулан зохион байгуулвал нарийвчлан судалж, тооцоолон төлөвлөж эхлүүлсэн хог хаягдлын менежментийн тогтолцоонд ямар нэг байдлаар сөрөг нөлөө үзүүлэхгүй байх талаар онцгой анхаарах нь чухал. Жишээлбэл, эх үүсвэр дээр нь хог хаягдлаа ангилсан байдал нь ХХЗТ-ийн үйл ажиллагааг сааруулахгүй, алдаагүй байх ёстой болно. (ялангуяа энэ ангилах процессийг хог үүсгэгчид өөрсдөө хариуцаж ХХМТ хүргэж өгдөг нь өөрчлөгдвөл)

Яваандаа хогоо ямар ч алдаа дутагдалгүй ангилсан өрхүүдээс хогийг нь очиж ачих үйлчилгээг бага багаар нэвтрүүлж болно (ХХЗТ-д ангилсан хогоо хэд хэдэн удаа авчирч өгөөд сайн үнэлгээ авсан тохиолдолд). Хог хаягдлыг нь сар бүр тогтмол ачих ийм үйлчилгээг нэвтрүүлэх нь өрхүүд хогоо сайн ангилж сурах хөшүүрэг болно. Харин энэ үйлчилгээг нэвтрүүлсэн нь ажлын ачаалал, зардлыг ихээр өсгөх учиргүй, учир нь эх үүсвэр дээр сайн ангилсан бол төв дээр хийгдэх ажил багасах ёстой: төвд хийх нарийвчилсан ангилалтын ажил багассанаар хог цуглуулах, ачих үйлчилгээнд гаргах цаг илүү гарна.

3. ХОГ ХАЯГДАЛ ЗОХИЦУУЛАХ ТӨВ

ХОГ ХАЯГДАЛ ЗОХИЦУУЛАХ ТӨВИЙН БАЙРШИЛ

Хог хаягдал зохицуулах төв нь Хишиг-Өндөр сумын суурьшлын бүсийн зүүнтээ, одоогийн төвлөрсөн хогийн цэгээс хойшхи үйлдвэрлэлийн бүсэд байрладаг. Байршлын газрын зургийг доороос харна уу.



ХХЗТ-ИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ, ДЭД БҮТЭЦ

Хог хаягдал зохицуулах төв нь ойролцоогоор $2,500\text{m}^2$ (50x50м) талбайтай. Газрын байдал нь Баруунаас (өндөр цэг) Зүүн зүгт (нам цэг) налуу (ойролцоогоор 7%).


ХХЗТ-ийн зохион байгуулалтад:

- Хог үүсгэгчид (байгууламжийн “хэрэглэгчид”) эх үүсвэр дээр нь ангилсан хог хаягдлаа авчирч, хог хаягдал хариуцсан ажилчид (ХХЗТ-ийн ажилчид) дахивар хаягдлуудыг зохих аргаар зохицуулах үндсэн барилга;
- Нарийвчлан ангилсан, боловсруулсан дахиваруудыг эцсийн шийдэл хүртэл (хот суурингийн дахин боловсруулах үйлдвэрүүдэд хүргэх эсвэл орон нутагтаа дахин

боловсруулах) цэвэрхэн түр хадгалах зорилготой үндсэн барилгад хавсаргасан агуулахын барилга;


- Хог хаягдал зохицуулах машин техникийг өвлийн хүйтнээс хамгаалах граж;
- Эцсийн хогийн савны дэргэд тусгайлан гаргасан газар тариалангийн салбарт ашиглах боломжтой модны үнсийг түр хадгалах цэг;
- Шаардлагатай бол хүнсний хаягдал бордоошуулах цэг байгуулах (ногоон хаягдал болон амьтны гаралтай хаягдлыг холихгүй байх);
- Хэрэв шаардлагатай тохиолдолд багаж, тоног төхөөрөмж хадгалах байр, бусад төрлийн хог хаягдал түр хадгалах агуулах, саравч гэх мэтийг зохистой талбайд шинээр барих боломжтой.

ХХЗТ-ийн ерөнхий төлөвлөгөөг доороос харна уу.




ХОГ ХАЯГДАЛ ЗОХИЦУУЛАХ ҮНДСЭН БОЛОН АГУУЛАХЫН БАРИЛГА

Үндсэн барилгад хэрэглэгчид ангилсан дахиваруудаа авчирч хүлээлгэн өгөх нээлттэй хэсэг болон ХХЗТ-ийн ажилтан дахиваруудыг нарийвчлан ангилж, дахин боловсруулах зөвхөн үйлдвэрийн ажилтанд нээлттэй үндсэн хоёр хэсгээг бүрднэ (доорх зурагт: саарал дөрвөлжингүүд нь дахин боловсруулах тоног төхөөрөмжүүд, хөндлөн хар зураас нь хэрэглэгчдэд зориулсан дахивараа ангилж, хүлээлгэж өгөх тавцан). Агуулахын барилгад үндсэн барилгаас нэвтрэх боломжтой, дахиваруудыг хот суурингийн дахин боловсруулах үйлдвэрт хүргэх эсвэл орон нутагтаа дахин боловсруулах хүртэл аюулгүй, цэвэрхэн хадгалах хангалттай талбай бүхий байна.




Тус тавцанд хэрэглэгчид төрөл бүрийн дахиваруудаа хийх нүхнүүд байрлана (ус ундааны савны нэг нүх, шилний нэг нүх гэх мэтээр). Нүхний дор дахивар тус бүрт зориулсан савыг байрлуулна.



ЭЦСИЙН ХОГ ХҮЛЭЭН АВАХ ЦЭГ

Эцсийн хог хүлээн авах цэгийг хэрэглэгчид хогоо буулгахад мөн ажилтан хогны машинд ачиж төвлөрсөн цэгт хүргэхэд аль болох хялбар, дөхөм байхаар төлөвлөнө. Газрын зүүн тийш налуу байдлыг тооцвол багахан газар шорооны ажлын тусламжтайгаар 2 юм уу 3 түвшинд (доорх зурагт үзүүлснээр) хэрэглэгч дээд талд нь зогсож (Баруун зүгт) байрлуулсан саванд хог хаягдлын хялбар буулгах бөгөөд ажилтан доод талд нь (Зүүн зүгт) машинаа байрлуулж савнаас хогийн машинд төвөггүй ачих боломжтойгоор зохион байгуулах боломжтой юм.



ХОГ ҮҮСГЭГЧИЙН МАРШРУТ

Хэрэглэгчид (хог үүсгэгчид) маршрутаа ХХЗТ-ийн үрд гол хаалгаар нэвтэрч үндсэн барилгын гадна машинаа зогсоон дотогш орж дахиваруудаа хүлээлгэж өгснөөр эхүүлнэ.

Барилгын олон нийтэд нээлттэй хэсэгт дахивар тус бүрт зориулсан нүх бүхий тавцан байрлах бөгөөд эх үүсвэр дээр нь цэвэрхэн ангилсан дахиваруудаа тэдгээрт салгаж хийнэ. Хэрэглэгчдэд ХХЗТ-ийн ажилтан (ангилах тавцангийн нөгөө талд ажиллаж буй) шаардлагатай тохиолдолд туслах бөгөөд зөв ялгаж байгаа эсэхийг хянана.

Хэрэглэгчид зөвхөн ажилтнуудад нээлттэй дахин боловсруулах хэсэгт нэвтрэх боломжгүй ч ангилалт, үйл явцыг харах боломжтой. Ингэснээр бүх ажиллагаа, явц ойлгомжтой байх төдийгүй сониуч иргэдэд хог хаягдал зохицуулах, дахин боловсруулах, эргэлтэнд оруулах талаар сонирхолтой мэдээлэл олгох ч боломжтой юм.

Ангилсан дахиваруудаа үндсэн барилгад үлдээсний дараа үнс, эцсийн хог гэх мэт зарим төрлийн хог хаягдал үлдсэн байна. Эдгээрийг бусад хог хаягдалд зориулсан цэг бүрт буулгана. Энэ үед байгууллагын ажилтан хамт явах бөгөөд эцсийн хог хаягдалд дахивар материал ороогүй эсэхийг шалгаж, хэрэглэгч үлдсэн хог хаягдлаа зөв цэгт хаяж байгаа эсэхийг мөн хянах юм. Хэрэв дахивар материал эцсийн хогтой холилдсон бол үндсэн барилга руу аваачиж ангилна.


Ингээд бүх хог хаягдлаа заасан цэгт тушааснаар төвлөрсөн хогийн цэг рүү явах шаардлагагүйгээр ХХЗТ-ийн хашаанаас гарч явна.

Хэрэв зарим тохиолдолд хог үүсгэгчид болон ХХЗТ-ийн ажилтнууд санал нэгтгэйгээр хэрэглэгчийн машинтай хогийг хогийн цэгт шүүд хүргэх шаардлагатай гэж үзвэл (жишээ нь иргэн машин дүүрэн барилгын хог хаягдалтай ирвэл) ажилтан хамт явж, эцсийн хог хаягдлыг заасан цэгт аюулгүй, зөв хаяж буй эсэхэд өөрийн биеэр хяналт тавина.

ХОГ ХАЯГДЛЫН АЖИЛТНЫ ЗОХИЦУУЛАХ ДАХИВАР ХОГ ХАЯГДЛУУД

Хэрэглэгчид ангилсан дахиваруудаа авчирч хүлээлгэн өгөхөд дахивар тус бүрийг тавцангийн доод талаас ажилтан дахин нарийвчилж ангилна. Ингээд дахиварын төрөл тус бүрээр урьдчилсан тогтоосон үйл ажиллагааны дарааллын дагуу цааш нь боловсруулна. Энэ явц, дараалал цаашид өөрчлөгдөж болох ба одоогоор үндсэн зарчмууд нь дор дурдсанаар байна:

- Ус ундааны сав буюу PET хуванцар савыг пресслэж агуулахад хадгалаад хот суурингийн дахин боловсруулах үйлдвэрүүдэд хүргэж өгнө. Бусад төрлийн хуванцрыг худалдан авагч, үйлдвэрүүдийн шаардлагад нийцүүлэн боловсруулна. Үлдсэн бусад хуванцарыг төрөл, өнгөөр нь нарийвчлан ангилаад буталж, угаагаад түр хадгалах ба хангалттай түүхий эд бүрдсэн үед хуванцар хавтан шахах машин болон хэвэнд цутгагч машин ашиглаж дахин боловсруулна.
- Үйлдвэрүүд нь эргүүлэн авдаг шилэн сав, лонхнуудыг стандартын дагуу бэлтгэж хадгалаад тэдгээр үйлдвэрүүдэд хүлээлгэн өгнө. Бусад төрлийн шилийг бутлаад цаашид хэрэглэх хүртэл түр хадгална.
- Хоол хүнсний хог хаягдлыг мал амьтанд өгөх болон бордоо хийхэд ашиглана.
- Дахин ашиглах боломжтой цаасан хайрцагнуудыг хэрэгтэй хүнд нь өгөх, өөрсдөө дахивар хадгалах саваар ашиглах, дахин ашиглагдахгүй цаасыг хот суурингийн цаас дахин боловсруулах үйлдвэрт хүргэх, орон нутагтаа (бордоо хийх, хуурай жорлонд ашиглах гэх мэтээр) ашиглана.
- Хөнгөн цагаан лаазнуудыг ПЕТ хуванцарын адил прессэлж түр хадгалаад хотын дахин боловсруулах үйлдвэрт худалдана.
- Монгол улсад зохистой зохицуулах суваг, шийдэл одоогоор байхгүй хог хаягдлыг (Тетра Пак, электрон хаягдал гм):
 - боломжтой/шаардлагатай бол: зохицуулах сувагтай болох хүртдээ ангилж, хянан мэдээлэл цуглуулж хадгалах;
 - бусад тохиолдолд хогийн цэгт булах.



1. Дахиваруудыг тавцан дороос авч цааш нь нарийвчлан ангилна. 2. PET буюу ус ундааны савыг пресслэнэ. 3. Бусад төрлийн хуванцруудыг бутлана. 4. Бутласан хуванцрыг угаалгын машинаар угааж ханан пийшингийн тавцан дээр хатаана. 5. Цэвэр, бутласан хуванцрыг төрөл, өнгөөр нь ангилж хадгална. 6. Хуванцарыг хавтангийн машин болон хэвэнд цутгах машинаар дахин боловсруулна. 7. Ангилсан/боловсруулсан дахиваруудыг агуулах руу зөөж хадгална. 8. Дахивар тус бүрийг заасан газар цэгцтэй хадгална. 9. Шаардлагатай үед дахиваруудыг агуулахаас ачиж, тээвэрлэнэ.

Орон нутагтаа дахин боловсруулсан бүтээгдэхүүнүүдийг иргэдийн санал хүсэлтийн дагуу, орон нутгийн ЗДТГ-тай хамтран дотооддоо зарж борлуулна. Гадагш тээвэрлэх дахиваруудыг Баруун хаалгаар ачааны машинд ачиж хот суурингийн дахин боловсруулах үйлдвэрүүдэд хүргэнэ.

ХОГ ХАЯГДЛЫН АЖИЛТНЫ ЗОХИЦУУЛАХ ЭЦСИЙН ХОГ

Ангилж, бэлтгэсэн дахиварууд хангалттай их цугларсан үед ачааны машин хөлсөлж дахиваруудыг хот суурингийн боловсруулах үйлдвэрүүд рүү тээвэрлүүлнэ.

Эцсийн хогийн сав дүүрэхэд ажилтан хогны машинд эцсийн хогийг ачиж төвлөрсөн хогийн цэгт аваачиж хаяна.

4. ТӨВЛӨРСӨН ХОГИЙН ЦЭГ


ХУУЧИН ТӨВЛӨРСӨН ХОГИЙН ЦЭГИЙН ТАЛБАЙГ ХУМЬЖ, ХАМГААЛАХ

Одоогийн нээлттэй, тархсан хогийн цэгийн талбайг хумьж, цэвэрлэн цэвэрхэн ландфилл болгож цаашид зохион байгуулалтай, зүй зохистойгоор ашиглана.



Одоогийн тархсан хогийг цуглуулан хамж ойролцоогоор 4га орчим газарт бөөгнүүлнэ (одоогоор 100 гаран га газар тархсан байгааг доорх газрын зургаас харна уу). Дээрх ажлын дийлэнхийг техникийн хүч ашиглан хийхийг зорих ч хад асга ихтэй, эсвэл жалга шуудуутай газар хүний гараар түүж цэвэрлэн, бүр мөсөн цэвэрлэж авах шаардлагатай.

Хумьж, цэвэрлэсэн талбайг хэвээр үлдээж хогийн цэгийг далан, хашаагаар хашиж, хамгаалах шаардлагатай (доорх зургийг харна уу). Ганцхан орц, гарц бүхий хаалгыг далангийн гадуурх хашаанд байрлуулна. Хяналтын камерыг дор хаяж хашаа, хаалгыг хянах, боломжтой бол хогийн цэгийг бүхэлд нь хянах боломжтой газар байрлуулах. Бөөгнүүлсэн бүх хог хаягдал болон босгосон даланг хөрс, эсвэл тохиромжтой материалаар дарж хог хаягдал салхинд хийсч тархах, мал амьтан идэхээс сэргийлэх.



ХАШИЖ ХАМГААЛСАН ЛАНДФИЛЛИЙН АШИГЛАЛТ

Талбай хүмийх, хашиж хамгаалах ажлын дараа (боломжтой бол бүр ажлын явцад) ландфиллд орж гарах эрхийг зөвхөн ХХЗТ-ийн ажилтанд олгох хэрэгтэй. Хог үүсгэгчид зөвхөн нэн шаардлагатай тохиолдолд (өөрсдийн машинаар тэвшин дээрх хогоо шууд буулгаж хаях шаардлагатай бол) эрх бүхий хүний хяналтан дор ландфиллд нэвтэрч хогоо хаяна.

Ландфиллд хаягдах бүх хогийг хог хаягдал хариуцсан ажилтан дахивар хаягдал холилдсон эсэх, дахин ашиглах, эргэлтэнд оруулах боломжтой хаягдал байгаа эсэхийг шалгана.

Хаясан эцсийн хогийг булдозероор түрж шахаж өгнө. Хөрс шороо эсвэл уурын зуухнаас гарах үнс гэх мэт хүнд материалаар ойр ойрхон дарж булан хог тархахаас сэргийлнэ. Энэ ажлыг сард дор хаяж нэг удаа (боломжтой бол хог хаях бүрт) мөн түүнчлэн хөнгөн, хялбар тархах төрлийн хог хаягдсан тохиолдолд гүйцэтгэх шаардлагатай.

5. БУСАД ОНЦГОЙ ХОГ ХАЯГДАЛД ЗОРИУЛСАН ЦЭГҮҮД

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ

Улаанбаатар хотод аюултай хог хаягдлыг хууль, журмын дагуу авч устгадаг газрууд руу зөөвөрлөх боломжтой бол энэ шийдлийг мөрдөх нь зүйтэй.

Хэрэв Хишиг-Өндөр суманд аюултай хог хаягдлыг түр хадгалах шаардлагатай бол хөрс, ус агаар бохирдуулахгүй, аюулгүй байдал хангасан нөхцөлд байх шаардлагатай. ХХЗТ-ийн хашаанд аюултай хог хаягдал түр хадгалахад зориулсан талбайг зааж өгснөөр бусад хог хаягдалтай холилдохоос урьдчилан сэргийлнэ.

Олон төрлийн аюултай хог хаягдлыг нэг дор хадгалж хэрхэвч болохгүй. Аюултай, хортой урвал явагдахаас сэргийлэх нь чухал. Хадгалж буй аюултай хог хаягдлын шинж чанараас хамаарч зохистой материалаар хийгдсэн (төмөр эсвэл хуванцар) 100% ус нэвтрэхгүй саванд хадгалах шаардлагатай.

Аюултай хог хаягдал суманд булагдсан бол хянаж, хадгалагдаж буй аюултай хог хаягдлыг нарийн бүртгэх шаардлагатай. Өвчтэй мал, амьтан булсан бол цэгийг тэмдэглэж, анхааруулах тэмдэглэгээг газар дээр нь байрлуулах шаардлагатай.

АМЬТНЫ СЭГ ЗЭМ

Амьтны гаралтай хог хаягдал: амьтны сэг зэм, яс, өөх гэх мэтийг хаях тодорхой цэгийг зааж өгөх хэрэгтэй. Энэ цэгийг хүн, мал, нохой нэвтрэхээс сэргийлж хаших нь чухал. Зөвхөн сэг зэмээр хооллодог шувууд дээрээс нь орох боломжтой байж болно. Ингэж байгалийн аргаар энэ төрлийн хог хаягдлыг зохицуулах боломжтой юм.

Харин халдварт өвчнөөр үхсэн байж болзошгүй мал, амьтныг энэ цэгт хүргэхгүй. Тэдгээрийг тусгайлан заасан, хамгаалсан газарт дүрэм, журмын дагуу булна. Зуны цагт урт шүүдүү ухаж бэлтгэвэл өвлийн цагт өвчнөөр үхсэн малыг булах боломжтой.

Үхсэн мал, амьтны сэг зэмийг эцсийн хогтойгоо хэрэглэгч авч ирэх үед ажилтан өөрийн биеэр дагалдан явж тусгайлан заасан газарт хяналттайгаар хаяулна.

БОХИРЫН ХАЯГДАЛ

Бохирын хаягдлыг ялзалж бордоо болгох нь зүйтэй. Бордоо хийх талбай нь ХХЗТ-тэй ойролцоо байх, эсвэл гарах хэмжээнээс нь хамаараад тусгайлан газар зааж асгуулж болно.

6. САНХҮҮГИЙН ЭХ ҮҮСВЭР БОЛОН ХАРИУЦАГЧ ТАЛУУД

САНХҮҮГИЙН ЭХ ҮҮСВЭР

Үйл ажиллагааны урсгал зардлыг хог хаягдал зохицуулахад зориулсан тусгай хураамжаар бүрдүүлж төлнө. Тус хураамжийг иргэдийн төлөөлөлөгчдийн хурлаар баталж сумын ЗДТГ хураах ба дор хаяж хоёр бүтэн цагийн ажилтны тогтмол цалин төлөхөд хангалттай байхаар тооцно.

Дахивар хаягдлаа дахин боловсруулагчдад худалдаж нэмэлт орлого олох боломжтой. Энэхүү орлогоор засвар үйлчилгээ, цахилгаан, түлш, тээврийн зардал гэх мэт урсгал зардлыг нөхөх ба боломжтой бол хог хаягдал зохицуулах тогтолцоог сайжруулахад зориулж нэмэлт ажиллах хүч авч (жишээ нь хог ачих, тээвэрлэх үйлчилгээг нэвтрүүлэхэд) болно.

Шаардлагатай хөрөнгө оруулалт (шинэ ачааны машин гэх мэт)-ыг сум, аймгийн төсөвт тусгаж хийх шаардлагатай.

ХАРИУЦАГЧ ТАЛУУД

Олон нийтийн эрх ашгийг хамгаалах, хог хаягдлын зохицуулалт далайцтай, үр дүнтэй хийгдэхэд бүрэн хяналт тавих боломжтой байхын тулд орон нутгийн ЗДТГ хог хаягдал зохицуулах ажлыг үргэлж хариуцах ёстой. Эс бөгөөс энэ нь зөвхөн үнэ хүрэх дахиваруудыг л зарж борлуулдаг хувийн бизнес, нурсан салбар болох эрсдэл хэт өндөр юм. Иймээс хамгийн зөв шийдэл нь сумын ЗДТГ хог хаягдал зохицуулалтыг өдөр тутамд гардан хариуцаж ажиллах хүмүүсийг гэрээ байгуулан шууд ажилд авч өөрсдийн шууд хяналтад байлгах юм.

Хэрэв ингэх боломжгүй бол хог хаягдал зохицуулах ажлыг хувийн байгууллагатай гэрээ байгуулан хариуцуулж болох ба ингэхдээ аль болох ашгийн бүс байгууллага эсвэл орон нутгийн иргэдийн өөрөө удирдах байгууллагын хэлбэрийг сонгох нь зүйтэй. Үүний жишээ нь нутгийн иргэдийн байгуулсан хоршоо байж болох юм.

Ажлыг гэрээгээр гүйцэтгүүлэх тохиолдолд ажил үүргийн хуваарь, хүлээгдэх үр дүн зэргийг гэрээндээ сайтар тусгах нь чухал бөгөөд зөвхөн гүйцэтгэгч талын арга барилд найдаж орхиж огт

болохгүй. Тодруулбал, гүйцэтгэгчийн үзүүлэх тодорхой үйлчилгээг (жишээ нь: сумын хог хаягдал зохицуулах журмын дагуу бүх төрлийн хог хаягдлыг зохицуулах) сум санхүүжүүлэх ба гүйцэтгэгч үйл ажиллагаагаа дахиварын худалдааны орлогоор санхүүжүүлнэ гэх мэт тогтворгүй тогтолцоо руу хальтрахгүй байх нь нэн чухал. Энэ нь хувийн бизнесийн чиг хандлагатай, эрсдэл өндөртэй, тогтворгүй арга юм. Иймээс дахивараас олох орлого нь зөвхөн хог хаягдлын зохицуулалтыг сайжруулахад зарцуулагдах, эсвэл сумын төсөвт төвлөрч эргээд гүйцэтгэгчийн санхүүжилтийн нэг эх үүсвэр болох нь зүйтэй.